

Сарны хэлбэрийг ажиглах туршилт

Хамрах хүрээ 7-р анги


Бүлэг сэдэв Одон орон, 4-р улирал

Зорилго Сарны хэлбэр яагаад өөрчлөгддөг болохыг хялбар туршилтаар ажиглаж, дүгнэлт гаргах.

Хичээлийн явц



Хугацаа /минут/	Үе шат	Багш	Сурагч
5	Сэдэл, таамаглал	Сарны хэлбэр яагаад өөрчлөгддөг вэ?	Сурагчид өөрийн таамаглалаа зургаар илэрхийлж зурах.
10	Төлөвлөгөө	Туршилтын төлөвлөгөөг сурагчидтай хамтран гаргах.	Багаараа ярилцаж ажлын хуудсан дээр төлөвлөгөө бичих.
18	Туршилт	Багууд туршилт гүйцэтгэх явцад багш чиглүүлж, туслах.	Багууд төлөвлөгөөний дагуу туршилтыг гүйцэтгэж ажиглах.
7	Үр дүн	Үр дүнг зургаар илэрхийлж, таамаглалтай хэрхэн нийцэж байгаа талаар хэлэлцэх. Яагаад өөр байгаа талаар ярилцалах.	

Таамаглал Сарны хэлбэр яаж харагдах вэ? Өөрийн бодлоо зургаар илэрхийлнэ үү.




Хэрэглэгдэхүүн маркер, хар, шар, цэнхэр өнгийн, шугам, теннисний бөмбөг, гортиг, гар чийдэн, ажиглагч хүүхэд\ цаасан\ , бичгийн цаас, шүдэнзний хайрцаг, тогтоогч зүү

Туршилтын бэлтгэх Доошын зураг шиг хэрэглэгдэхүүнийг хийх.




Туршилтын явц

1. Нар, сар, дэлхийн байрлалыг зурсан бичгийн цаасыг ширээн дээр дэлгэж тавих.




2. Ажиглагч хүүхдийг дэлхий дээр байрлуулах.

Санамж: Сарыг 1,2,3... 8 байрлалтай адилхан байрлуулж ажиглаарай. Нарыг гар чийдэнгээр төлөөлүүлж байна. Гар чийдэнг байрнаас нь хөдөлгөж болохгүй.



3. Сарыг 1-8 дугаарын байрлалд байрлуулж, нарны гэрлийг тусгалах.





4. Ажиглагч хүүхдийн байрлал тус бүрд сарны хэлбэр ямар харагдаж байгааг сайтар ажиглаж, зургаар илэрхийлэх.

Үр дүн хэлэлцэх асуултууд Байрлал тус бүр дээр сарны хэлбэр ямар харагдаж байсан бэ? Яагаад өөр өөр хэлбэртэй харагдсан бэ? Шалтгааныг тайлбарлана уу?

※Таамаглал ба туршилтын үр дүнгийн талаар хэлэлцэж, үр дүнг тодорхойлно.

Үр дүн



Дүгнэлт Сарыг ажиглахад сарны байрлал зүүн зүг тийш шилжин өөрчлөгдөж байна. Хавирган сар гарснаас хойш сарны хэлбэр томорсоор бүтэн дугуй болж харагдаж байна.

Багшид өгөх санал Туршилтын хэрэглэгдэхүүнийг сурагчидтай хамтарч хийж болно. Мөн ажиглалт, туршилт хийх төлөвлөгөөг хамтран гаргах хэрэгтэй. Шинийн 2, 8, 15, битүүний сар аль байрлалд үүсэж байгаа талаар ярилцаж, ажиглалтын дүгнэлтийг хэлэлцэх.

Туршилтын төлөвлөгөө бичсэн :

Дундговь аймгийн “Эрдмийн далай цогцолбор” сургуулийн физикийн багш А.Уранчимэг



Жайкагийн сайн дурын гишүүн Фүкүшима Мики

Сарны хэлбэрийг ажиглах туршилт

Зорилго Сарны хэлбэр яагаад өөрчлөгддөг талаар ажиглах туршилтыг багаараа гүйцэтгэх.

Хэрэглэгдэхүүн Зураг, гар чийдэн, сар ажиглах төхөөрөмж

Таамаглал





Туршилтын төлөвлөгөө

1.
2.
3.
4.

Анхаарах зүйлс:

Үр дүн



Дүгнэлт

.....
.....
.....

Анги.....нэр.....